

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ТӨВИЙН 2025 ОНЫ I УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025-03-31

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн уялдаа	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ ТУСГАГДСАН ЗОРИЛТ							
Гүйцэтгэлийн зорилт:1.1 Ажиллагсад болон үйлчлүүлэгчдэд ээлтэй орчинг бүрдүүлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сайжруулж ажиллана							
1.1.1	Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (2021-2025) 2.2.2, 2.2.3	Эрүүл мэндийн салбарын хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа зорилтот хөтөлбөр, арга хэмжээнүүдийг өөрийн тусламж үйлчилгээнд зохицуулан хэрэгжүүлж ажиллана.	БӨХ	80%	85%	Үйлчлүүлэгчдийг идэвхтэй дасгал хөдөгөөнд уриалж, дасгал хөдөлгөөнөөр хичээлэх, эрүүл аж төрөх, зан үйлд суралцуулах, өөрийгөө хөгжүүлэх сонирхол санаачлагыг нэмэгдүүлэх зорилгоор хэвтэн эмчлүүлэгсдэд хятадын таван цулын дасгал хөдөлгөөнийг өглөө бүр хийлгэж, ажилчдад шугаман бүжгийг өдрийн цайны цагаар 15 минутаар тогтмол хийлгэж хэвшүүлсэн. Байгууллагын хэмжээнд цанын баазад эрүүл агаараар амьсгалья 1 өдрийн аялалыг гэр бүл, үр хүүхдүүдийн хамт 2025 оны 02 дугаар 15-ны өдөр зохион байгуулж тогооч А.Хажидмаагийн гэр бүл тэргүүн байр эзэлж шагнаж урамшуулсан. Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төв, Биеийн тамир спортын	100

					газартай 1 жилийн хугацаатай гэрээ байгуулан ажиллаж, бүх ажилчдын дунд волейбол, дардас, теннис зэрэг спортын төрлүүдээр 3 сарын аян зохион байгуулж 1-р байр Б.Нямдаваа ахлагчтай баг тэргүүлсэн тул үр дүнгийн урамшуулал дээр 5 хувийн урамшуулал олгохоор шийдвэрлэсэн. Завхан аймагт Улаанбаатар хотоос ирсэн шугаман бүжгийн 4 багштай хамтарч “Хөдөлгөөн эрүүл мэнд” сэдэвт 2 өдрийн сургалтад хамрагдаж хүзүү, нурууны булчин суллах бүжиг, сарнай бүжиг, цасан хаялга бүжгүүдийг сурч үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж 4 багшийг 1 өдрийн хоолоор үйлчилсэн.	 
--	--	--	--	--	--	--



1.1.2	Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө	Хий өвчний эмнэлзүйг нарийн судалж эмчлэх аргыг өөрийн байгууллагын брэнд болгоно.	БӨХ	0	1	Таван мэдрэхүйн хий өвчнөөр хүүхдүүд ялангуяа утаснаас үүсэлтэй хий өвчин ихсэж байна. Хүүхдүүдэд утасны дон хэлбэрээр ихээхэн тохиолдож байгаа нь тус эмнэлэгт 5-18 насны 28 хүүхэд үйлчлүүлснээс бүгд утсаар тоглох, утас үзэж хоол идэх үед эцэг, эхчүүд нь хүүхдүүдээ зугаацуулах, шагнаж урамшуулах хэлбэрээр ашиглаж байна. Иймд эцэг эхчүүд болон хүүхдүүдэд цаашдын хор уршгийг тайлбарлан зөвлөмж зөвлөгөө өгч ажилласан. Хий өвчний оноштой 9 хүн хэвтэн эмчлүүлсэн ба биеийн ерөнхий байдал дунд байснаас бүгд биеийн ерөнхий байдал хөнгөрч эмчилгээнд биеийн байдал бүгд сайжирсан байна.	100
1.1.3	ЗГ-ын Үйл ажиллаганы хөтөлбөр (2020-2024) 1.1.3.1, 1.1.3.3	Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ./Менингококкт халдвар/	БӨХ	70%	80%	Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлэн ажиллахад эмийн нөөцөд 76 нэр төрлийн 2600.0 мянган төгрөгийн эм тариа, хувцас хэрэгслийн нөөцтэй байна. 9 номерын өрөөг хүүхэд өсвөр үеийн өрөө болгон тохижуулсан. 12 номерыг өрөөг тусгаарлах өрөөгөөр тохижуулсан. Ажилчдад амьсгалын замын халдварт өвчний үед бэлэн байх дадлага сургалтыг 1 удаа зохион байгуулсан. Эрүүл мэндийн газрын хяналт шалгалтын хэлтсийн улсын ахлах байцаагчийн ирүүлсэн албан шаардлагын дагуу 13 үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд: - 5а өрөөг өсвөр үеийнхэнд эрүүл	100

					мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх өрөө болгон тохижуулсан.Өсвөр үеийнхэнтэй ярилцлага хийх боломжтой байдлыг хангасан. - Өсвөр үеийн их эмчээр Б.Сосорбурам, сувилагчаар П.Ганбилэг нарыг томилон, өсвөр үеийнхэнд тохиолдох халдварт болон халдварт бус өвчнийг оношлох, эмчлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх шаардлагатай тохиолдолд дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлэх ажлыг хариуцан ажиллаж байна. - Их эмч Д.Өлзийбаяр, сувилагч Ч.Юнрэндорж нар нь Улаанзагалмай нийгэмлэгтэй хамтран Улиастай хотод байрлах 3-р 10 жил, 1-р 10 жил, 4-р сургуулийн 10-12 ангийн хүүхдүүдэд жил бүр үзлэг оншилгоо, сургалт, ярилцлага хийсэн. - Дүн бүртгэгч Б.Ариунжаргал өсвөр үеийн үзлэгийн мэдээ судалгааг хариуцан Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны албанд хүргүүлэн ажиллаж байна. - Үзлэг оншилгоо, зөвлөгөө өгөх үйл ажиллагаанд шаардлагатай багаж тоног төхөөрөмж, сургалтын брошур, гарын авлага материалаар хангаж нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлэхэд шаардагдах 500,0 мянган төгрөг төсөвлөсөн. - Өсвөр үеийн кабинетийн ажиллах дүрэм боловсруулан батлуулсан ба дүн бүртгэгч Б.Ариунжаргал хүн амын бүртгэл, өвчлөлийн судалгааг хариуцан шилжилт хөдөлгөөний мэдээлийн сан үүсгэн ажиллаж байна.	
--	--	--	--	--	---	--

1.1.4	Завхан аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Тусламж үйлчилгээний төрөл, кабинетүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих шалгуур, хяналтын хуудсанд хяналт тавьж хэрэгжилтийг ханган ажиллана.	БӨХ	5	8	Тусламж үйлчилгээний төрөл, кабинетүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих шалгуур, хяналтын хуудсыг чанарын баг 10, сувилахуйн баг 17, халдвар хамгааллын баг 11 үзүүлэлтээр тус тус хяналт тавьж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Ээлжийн сувилагч нараас бүтэн биеийн бариа заслаар үнэлгээ хийхэд 96,9% үнэлэгдсэн.	100
ХОЁР.ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ							
Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт: 2.1 Төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй чанартай хүргэх							
2.1.1	Завхан аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Чанарын аян, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулна.	БӨХ	3	4	Эрүүл мэндийн газар, Уламжлалт анагаах ухааны төв хамтран “Уламжлалт анагаах ухааны аргаар эрүүл мэндээ хамгаалъя” нээлттэй хаалганы өдөрлөгийг 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр Уламжлалт анагаах ухааны төв эмнэлэгт зохион байгуулж Уламжлалт анагаах ухааны төвийн дарга Д.Өлзийбаяр “Монголын уламжлалт анагаах ухааны талаар товч ойлголт” сэдвээр илтгэл тавьсан. 	100

					“Уламжлалт анагаах ухааны аргаар эрүүл мэндээ хамгаалья” нээлттэй хаалганы өдөрлөгийн үйл ажиллагаанд нийт 50 хүн хамрагдаж, үүнээс 75 үйлчлүүлэгч нь үзлэг оношилгоо хийгдэж, өдөрлөгт хамрагдсан үйлчлүүлэгчдэд “Уламжлалт анагаах ухааны өвчнөөс урьдчилан сэргийлэх ёс”, “Зөв зохистой хооллолт”, “Идээ ундаагаа хэрхэн зохицуулж хооллох”, “Өвчин болох ёс”, “Таван цулын ач тус”, “Уламжлалт эмчилгээний үед барих гам цээр”, “Монгол эмийн тухай ойлголт”, “Идээ ундаагаар өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх ёс”, “Хүний биед улирал хэрхэн нөлөөлдөг”, “Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга”, “Хүний биед улирал хэрхэн нөлөөлдөг” зэрэг сэдвүүдээр брошур хийж 50 гаруй үйлчлүүлэгчид тарааж гарын үсгээр баталгаажуулсан. Эрүүл мэндийн газрын хоол тэжээл хариуцсан мэргэжилтэн Баянсан, халдварт болон халдварт бус хариуцсан мэргэжилтэн Ундармаа, Мягмаржаргал нар хэвтэн эмчлүүлэгчид болон үйлчлүүлэгчдэд “Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга”,	
						

						“Менингоккын халдвараас сэргийлэх зөвлөмж” зэрэг сэдвүүдээр сургалт хийж, гарын авлага тараасан.	
2.1.2		Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээг стандарт удирдамжийн дагуу багаар үзүүлдэг байх чадварт эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургана.	БӨХ	20%	50%	Яаралтай тусламжийн сувилагч П.Ганбилэг сувилагч нарт амь тэнссэн үеийн амилуулах тусламж үйлчилгээ сэдвээр бүх сувилагч нарт 2 удаа гардан үйлдэл хийлгэж үнэлгээ өгөн дадлагажуулсан. 	100
2.1.3		Яаралтай тусламжийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж эм, эмнэлгийн хэрэгслэл, нөөцийн бэлэн байдлыг хангаж ажиллана.	БӨХ	75%	80%	Эрүүл мэндийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/197 дугаар жагсаалтын дагуу яаралтай эм тарианы журналыг шинэчлэн боловсруулж, эм тариаг ханган ажиллаж байна.	100
2.1.3		Хэвлийн зөөлөн туулга ба жамзи эмчилгээг тусламж үйлчилгээнд шинээр нэвтрүүлэн ажилчдад дадлагажуулах сургалтыг явуулна.	БӨХ	0	20%	Хэвлийн туулга буюу туулга эмчилгээг 65 хүнд, зөөлөн шимт буюу жамзи эмчилгээг 1 хүнд хийсэн. Одь-тан эмийн үйлдвэрийн үүсгэн байгуулагч, Анагаах ухааны магистр, УАУ-ны ахлах зэргийн эмч Б.Ширчинмаа нь Уламжлалт анагаах ухааны төвийн эмч сувилагч нарт 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр туулгах заслын	100

						талаар онлайн сургалт зохион байгуулж эмч, сувилагч нар хамрагдсан. Сургалтаар туулгах заслын тухай, туулгах заслын ангилал, үйлдэл, цээрлэх өвчин, туулгын найрлага, жолоодлого, туулгын 7 увидас, бэлтгэл   үе, туулга хийх арга, хүндрэл, сүүлийг таслах зэргээр сургалт явуулсан. Мөн Б.Ширчинмаа өөрийн “Элэгний архаг вируст гепатит буюу элэгний дэлгэрсэн халуун өвчнийг туулгаар эмчилсэн дүн” судалгааны ажлыг танилцуулсан. Нийт цөс угаах, туулгах засал эмчилгээг 65 үйлчлүүлгчдэд хийж ирээдүйн цөсний чулуу үүсэх, элэгний эмгэг үүсэх эрсдлээс сэргийлж ажиллаа.	
2.1.4	ЭМХТ-ийн 2022 оны 1152 албан бичгийн	Сувилахуйн эмнэл зүйн хэлэлцүүлгийг улирал тутам хийж хэвшүүлнэ.	БӨХ	2	4	Сувилахуйн эмнэл зүйн хэлэлцүүлгийг 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 16.30 минутад сургалтын өрөөнд эмч,	100


	дагуу шинжээчийн багийн зөвлөмж					сувилагч нар 100 хувь оролцов. Сувилагч, тусгай мэргэжилтнүүд сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэхэд гарч болзошгүй эрсдлүүдийг судалж илрүүлэхэд чиглэгдэнэ. MNS4621:2008 стандарт, уламжлалт анагаах ухааны төвийн эмчлүүлэгчдийн эрсдлийг үнэлэх самбар ашиглах шаардлагатай тул сувилагч нарын дунд хэлэлцүүлэг хийсэн. Эмчлүүлэгчдийн эрсдлийг үнэлэх самбарт асаргаа сувилгаа шаардлагатай 2 хүн, унах эрсдэлтэй 2 хүн, хануур шивүүр засал эмчилгээтэй 2 хүн, хэл яриа сонсгол, харааны бэрхшээлтэй 1 хүн, артерийн даралт ихтэй 4 хүн, эрсдэлтэй хооллолт 2 хүн, сахарын хяналт 1 хүн үйлчлүүлж эрсдлээс урьдчилан сэргийлж ажилласан. Сувилагчийн 7 хоногийн аян зарлаж сувилагч нарын дунд тулгамдаж буй асуудлаар хэлэлцүүлэг хийж барианы өрөөний хөшиг, агааржуулалт, бигнүүр халаагч печь, кварц зэргийг худалдан авч шинэчлэлт хийсэн. Барианы сургалтыг хийж туршлага солилцож дадлагажсан.	
--	--	--	--	--	--	--	--

2.1.5	Байгууллагын дотоод журам	“Лиштэй тэжээлэг зутан шөл”, “Элэгтэй төмсний хучмал” хийж байгууллагын брэнд хоол бий болгоно.	БӨХ	0	30%	Ахлах тогооч А.Хажидмаа, тогооч Д.Баярмагнай нар “Лиштэй тэжээлэг зутан шөл”, “Элэгтэй төмсний хучмал”-ний технологи картыг шинэчлэн баталгаажуулж, хэвтэн эмчлүүлэгч болон өөрсдийн ажилчдад “Кальцитай шөл” -өөр 184 хүнд, “Лиштэй тэжээлэг зутан шөл”-ийг 184 хүнд тус тус үйлчилж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаагаар сайн үнэлгээ авсан. 	100
-------	---------------------------	---	-----	---	-----	--	-----

“Уламжлалт анагаах ухааны аргаар эрүүл мэндээ хамгаалья” нээлттэй хаалганы өдөрлөгт үйлчлүүлэхээр ирсэн үйлчлүүлэгчдэд үзлэг оношилгоо, үйлчилгээ үзүүлэхээс гадна элэгний хучмал, мини пирошки, стүжин, царцаамаг, элгэн блинчиг, дэлүүний шорлог, аарц, чацарганы шүүсээр 50 гаруй хүнд үйлчилсэн.



2.1.6	ЭМС-ын 2022 оны А/352 дугаар тушаал	Үйлчлүүлэгчийг унах бэртэх эрсдэлээс сэргийлэх анхааруулга зааварчилгааг өгч ажиллана.	БӨХ	50%	70%	Үйлчлүүлэгчийг унах бэртэх эрсдэлээс сэргийлсэн 2 самбар, үзүүлэх маягт, таних тэмдэглэгээ, анхааруулгыг шаардлагатай цэгүүдэд байршуулж ажиллаж байна.Унах эрсдэл бүхий үйлчлүүлэгчийн бугуйнд нь тэмдэг тэмдэглэгээг зүүж ялган өрөөнд нь хоолыг нь зөөх, үйлчлэгч усанд оруулан арчилгаа сувилгаа хийх, эмчилгээ үйлчилгээг өрөөнд тусгайлан хийх зэрэг арга хэмжээнүүдийн авч ажилласан.	100
2.1.7	ЭМС-ын 2019 оны А/537 тоот тушаал	Шинэ ажилтанг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан байна.	БӨХ	0	100%	Шинээр ажилд орсон ажилтан байхгүй. Эмч, эмнэлгийн ажилчид урьдчилан сэргийлэх үзлэгт 2025 оны 01 дүгээр сарын 5-ны өдөр Одчим-Наран эмнэлэгт 14 ажилтан хамрагдаж ажилчдын дунд ханиад томуу, дархлаанаас үүсэлтэй өвчлөл их байсан тул дархлаа бэлдмэл өлзий 18 эм болон хоолойн цацлага, аскорбины хүчил, витамин-Д зэрэг 2.0 сая төгрөгийн эм бэлдмэлээр хангасан. Улаанбурханы вакцинд 9 ажилтан өрхийн эрүүл мэндийн төвд хамрагдсан.	100
2.1.8	ЭМС-ын 2019 оны А/537 тоот тушаал	Тусгаарлах өрөөг стандартын дагуу ажиллуулна.	БӨХ	50%	100%	Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537 дугаар тушаалын дагуу 12 номерын өрөөг тусгаарлах өрөө болгон стандартын дагуу тохижуулсан. 	100

2.1.9		Эрүүл мэндийн ажилтны гарын эрүүл ахуйн байдалд хяналт, үнэлгээ хийж үр дүнг тооцон ажиллана.	БӨХ	4	12	Эрүүл мэндийн ажилтны гарын эрүүл ахуйн байдалд хяналт, үнэлгээ хийж үр дүнг тооцон ажилласан. Гарын эрүүл ахуйн сахилтын ажиглалтын үнэлгээнд тусламж үйлчилгээнд оролцсон ажилладаг эрүүл мэндийн 10 ажилтанд жилд 1:1 үнэлгээ хийж дунджаар 93,89 хувьтай байна. 	100
2.1.10	ЭМС-ын 2019 оны 566 дугаар тушаал, ЭМС-ын 2020 оны А/625 тоот тушаал	Эм зүйн тусламжийн хүрээнд чанар аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийг боловсруулж, дүн шинжилгээ хийнэ.	БӨХ	2	4	2024 онд байгууллагын дотоод хяналтын багаас эмийн санд хяналт үнэлгээ хийхэд эм хадгалах шүүгээ стандартын шаардлага хангахгүй байна гэсэн дүгнэлт гарсан тул 2025 оны 1 дүгээр улиралд шинээр 2 ширхэг эмийн зориулалтын шкаф 2200,0 (хоёр сая нэг зуун) мянган төгрөгөөр худалдан авсан 	100
2.1.11	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоол	Ажилчдын хувийн хэрэг, албан тушаалын тодорхойлолт болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, мөрдөн ажиллана.	БӨХ	18	22	21 ажилтны нэгдүгээр улиралд хийх гүйцэтгэлийн төлөвлөгөөг гаргуулан даргаар батлуулж хувийн хэрэгт нь хийсэн.	100

						Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хэмжээнд 54 үйл ажиллагаа төлөвлөн Эрүүл мэндийн газрын даргаар батлуулан ажиллаж байна.	
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт: 3.1 Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах							
3.1.1	МУАУ-ны НЭ-ийн стандарт MNS 5700:2020	Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг өргөжүүлж батлагдсан орыг бүрэн ашиглана.	УТ	Орны фонд ашиглалт	Орны фонд ашиглалт	Үйлчлүүлэгчдэд уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтэн эмчлүүлэх тасаг гэсэн 2 чиглэлээр үзүүлж, эрүүл мэндийн газраас баталсан өдрийн 5 ор, хэвтүүлэн эмчлэх 35 ороор ажиллаж яаралтай тусламж, тусгаарлах өрөөг гарган 24 цагаар ажиллаж байна. Эхний 3 сарын байдлаар өссөн дүнгээр эмчлүүлсэн хүний тоо 369, ашигласан ор хоног 2457, дундаж ор хоног 19.9, орны фонд ашиглалт 70.9, орны эргэлт 10.4 байна. Амбулаторийн үзлэг 613, өдрийн эмчилгээ 97 байна.	100
3.1.2	Эрүүл мэндийн тухай хууль	Байгууллагын мэдээ мэдээллийн тайланг нэгтгэн холбогдох байгууллагад өгөх, мэдээний санд баяжилт хийнэ.	БӨХ	12	12	Тусламж үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагаанд мэдээллийн сангийн баяжилтыг тогтмол хийн статистик мэдээг 5 чиглэлээр сар бүр нэгтгэн ЭМГ-т мэдээллэсэн.	100
3.1.3	Засгийн газрын 2018 оны 382, 2019 оны 5 дугаар тогтоолууд	Эмч, эмнэлгийн ажилчдын ажлын үнэлэмжийг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж ур чадвар, үр дүнгийн урамшуулал олгоно.	БӨХ	21	21	Нэгдүгээр улирлын ажлыг 10 үзүүлэлтээр дүгнэж үр дүн, ур чадварыг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж одоогоор санхүүжилт бүрэн ирээгүй тул өгөгдөөгүй байна.	100

3.1.4	Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө	Эмч нарын ур чадварыг дээшлүүлж ЭХО болон зүрхний цахилгаан бичлэг хийх, унших ур чадварт сургана.	БӨХ	0	2	Аймгийн нэгдсэн эмнэлгийн дүрс оношлогооны их эмч Б.Отгонсүрэнтэй сургалтын гэрээ байгуулан “Хэвлийн хөндийн эрхтэнүүдийн хэт авиа оношлогооны онол, дадлага” хөтөлбөрийн дагуу ажлын байрны сургалтыг их эмч Э.Одгэрэлд 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 1 сарын хугацаатай зохион байгуулсан.Үүний үр дүнд ЭХО-ны аппаратаар 65 хүн оношилсон. Зүрх судасны их эмч Б.Индэрмаатай сургалтын гэрээ байгуулан “Зүрхний цахилгаан бичлэгийн үндэс ба зонхилон тохиолдох эмгэгийн оношилгоо, дадлага” хөтөлбөрийн дагуу 14 хоногийн ажлын байрны сургалтыг их эмч Б.Сосорбурамыг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 15 хоног зохион байгуулсан.Үүний үр дүнд зүрхний цахилгаан бичлэг 56 хүнд хийсэн.	100
3.1.5	ЭМХТ-ийн 2022 оны 1152 албан бичгийн дагуу шинжээчийн багийн зөвлөмж	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг төгсөлтийн дараах сургалт, багц цагийн сургалтад хамруулна.	БӨХ	80%	90%	Эм зүйн шинжлэх ухааны их сургуулиас 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан “Эмийн харилцан үйлчлэл, зохистой хэрэглээний асуудал” сэдэвт 1 багц цагийн танхимын сургалтад 2 эмч, 1 эм найруулагч хамрагдсан.	100
3.1.6		Нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгааг үйлчлүүлэгчдэд тогтмол хийж, гарын авлагаар ханган ажиллана.	БӨХ	50%	70%	“Уламжлалт анагаах ухааны аргаар эрүүл мэндээ хамгаалья” нээлттэй хаалганы өдөрлөгт хамрагдсан үйлчлүүлэгчдэд “ Уламжлалт анагаах ухааны өвчнөөс урьдчилан сэргийлэх ёс”, “Зөв зохистой хооллолт”, “Идээ ундаагаа хэрхэн зохицуулж хооллох”, “Өвчин болох ёс”, “Таван цулын ач тус”, “Уламжлалт эмчилгээний үед барих гам цээр”,	100

						“Монгол эмийн тухай ойлголт”, “Идээ ундаагаар өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх ёс”, “Хүний биед улирал хэрхэн нөлөөлдөг”, “Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга”, “Хүний биед улирал хэрхэн нөлөөлдөг” зэрэг сэдвүүдээр брошур хийж 50 гаруй үйлчлүүлэгчид тарааж гарын үсгээр баталгаажуулсан.	
3.1.7		Хүний нөөцийг ажлын байран дээр тасралтгүй сургах нөхцөл, боломжоор ханган сургалтын төлөвлөгөө гарган ажиллана.	БӨХ	70%	90%	Ажлын байранд тасралтгүй сургах сургалтын төлөвлөгөө гарган байгууллагын даргаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100
3.1.8	Өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль	Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх мэдээ, тайланг хугацаанд нь хүргүүлнэ.	БӨХ	85%	88%	Төрийн үйлчилгээ, захидал, эрүүл мэндийн зөвлөгөө, санал хүсэлт, өргөдөл, гомдол, хүлээн авах цагийн хуваарь, ажилтны утасны дугаар, и-мэйл хаяг зэргээр үйлчлүүлэгчдэд мэдээлэл өгөх журмын дагуу мэдээллийг хүргэн ажиллаж байна.	100
Дөрөв. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт 4.1 Байгууллагын дотоод хяналтыг сайжруулан, төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган өр авлаггүй ажиллаж, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн үр ашигтай зарцуулан ажиллана.							
4.1.1	МУАУ-ны НЭ-ийн стандарт MNS 5700:2020	Шинээр шинжилгээний аппарат, багаж тоног төхөөрөмжийн тоог нэмэгдүүлж өрөөнүүдийг түмбүчкээр хангаж тохижуулна.	БӨХ	70%	Гүйцэтгэл 100% байна.	Өөрийн хөрөнгө оруулалтаар агуулахын тавиур 4ш, зүүний тавиур 1ш, матрас 2ш, модон сандал 2ш, ор 2ш, 1-р хоолны тогоо 40л-1ш, шавар халаагч лист 1ш, ажилчдын шкаф -1ш нийт 14 ширхэг багаж тоног төхөөрөмж, эд хогшлыг 5756.9 (таван сая долоон зуун тавин зургаан мянга есөн зуун) төгрөгөөр худалдан авсан.	100

							
4.1.2	ЭМС АЗД-тай хамтран ажиллах гэрээний 3.2.17	Байгууллагуудын өр, авлагын байдалд хяналт тавин ажиллаж Төсвийн тухай хуулийн 6.2, 6.3, 6.4 болон 16.5.2, 16.5.3, 16.5.5, 57.5-д заасныг мөрдлөг болгон ажиллана.	БӨХ	өр авлага гаргааг үй	Өглөггүй ажиллана .	Төсвийн хөрөнгийг хуваарьт зүйл ангид нь зарцуулан сар бүр тайлан мэдээг гаргаж холбогдох газруудад тайлагнан тооцоо нийлж ажилласан. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 198.800.0 /нэг зуун ерэн найман сая найман зуун мянган/ төгрөгийн авлагатай, бусад байгууллагуудад 108.606.0 (нэг зуун найман сая зургаан зуун зургаан мянган) төгрөгийн өглөгтэй байна.	100
4.1.3	ЭМС АЗД-тай хамтран ажиллах гэрээний 3.2.18	Байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн жилийн тайланг Эрүүл мэндийн газраар нэгтгэн гаргуулж, аудит хийлгэн дараа оны 3 дугаар сарын 5-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулна.	БӨХ	зөрчилгүй санал дүгнэлт авсан	Аудитын санал дүгнэлт зөвлөмж байна	2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг төрийн аудитаар баталгаажуулан Эрүүл мэндийн газарт нэгтгэн тайлагнасан ба зөрчилгүй ажилласан.	100
4.1.4	Төрийн албаны тухай хууль	ЗГ-ын тогтоол шийдвэр, холбогдох хуулийн заалтуудыг танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	БӨХ	100%	100%	Монгол улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 6, 10, 11 дүгээр хавсралтын дагуу эмч, эмнэлгийн ажилчдын цалинг даргын 2025 оны Б/01 дүгээр тушаалаар шинэчлэн баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100

						Эмч, эмнэлгийн ажилчдын хоолны хөнгөлөлтийг нэмэгдүүлэн ажиллаж 1-р улиралд 24215.0 (хорин дөрвөн сая хоёр зуун арван таван мянган) төгрөг зарцуулсан. Ердийн галлагаатай сууцанд амьдардаг 2 ажилтанд түлээ, нүүрсний хөнгөлөлт болох тус бүр 1.0 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон.	
4.1.5	ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тушаал	Байгууллагын дотоод хяналтын баг хяналт шинжилгээ, үнэлгээг график төлөвлөгөөний дагуу хийнэ.	БӨХ	70%	100%	Дотоод хяналтын баг нь нэгдүгээр улиралд Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, Wings программ дээр хөтлөгдөж буй АШМБ-ийн хөтлөлтийн талаар хяналт үнэлгээ хийхэд стандартын шаардлага хангасан байна.	100
Тав.Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт							
Гүйцэтгэлийн зорилт 5.1 Байгууллагын ил тод байдлыг ханган ажиллана							
5.1.1	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6-р зүйл	Мэдээллийн ил тод байдал байдлыг ханган цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан тогтмол шинэчлэн ажиллана.	БӨХ	85	90	Эрүүл мэндийн даатгал болон санхүүжилт, дүн бүртгэлийн талаарх мэдээ мэдээллийн ил тод, харагдахуйц байдлаар байршуулан ажилчид болон үйлчлүүлэгчдийг тогтмол мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна. Мэдээллийн ил тод байдлыг ханган цахим болон мэдээллийн самбарт байрлуулан тогтмол шинэчлэн ажилласан.	100
5.1.2	Шилэн дансны тухай хуулийн 5, 6 дугаа зүйл ЗГ-ын 2016 оны 29-р тогтоол	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс	БӨХ	95%	96%	Санхүүгийн тайлан мэдээг хуулийн хугацаанд нь шилэн дансанд болон байгууллагын ил тодын самбарт байрлуулан ойлгомжтой байдлаар байрлуулан иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжоор ханган ажиллаж байна.	100

[illegible]

6.1	Хог хаягдлын тухай хууль, Аймгийн ИТХ-ын 2019 оны 56 тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны А/312 дугаар захирамж	Нийтийг цэвэрлэгээний хамарсан ажил, хариуцсан талбайн цас, мөсийг цэвэрлэхэд идэвхтэй оролцоно.	БӨХ	50 м хүртэл талбайд	Завхан аймгийн Улиастай сумын Хот тохижилт үйлчилгээний албанаас ирүүлсэн 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 53 тоот албан бичгийн дагуу байгууллагын гадна орчны их цэвэрлэгээг хийж гүйцэтгэсэн ба нийт 10 шуудай буюу 700 орчим кг хогийг цэвэрлэн ачуулсан.  	100
-----	--	---	-----	----------------------------	---	-----

6.2		Иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор зүүний өрөөний цонх болон бусад шаардлагатай засвар үйлчилгээг хийнэ.	БӨХ		Нийт ажилчид өөрсдийн хүчээр байгууллагын хөрөнгөөр иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор зүүний өрөөний цонх, шавар эмчилгээний өрөөг засварласан. Арын өрөөнүүдийн сантехникийн цагаан шугаман хоолойг төмөр хоолойгоор бүрэн шинэчилсэн. Нойлын өрөөний цаад хэсгийг цэвэрлэгээний материал хадгалах өрөө болгон тохижуулж шалыг шинээр пилталж бохирын хоолойг шинэчлэн засварласан.    	100
-----	--	--	-----	--	--	-----

